

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
Ж.ГАНБОЛД

2015 оны 05 сарын 15 өдөр

БАТЛАВ  
“НОМ ХУР” ХХК-НИЙ ЕРӨНХИЙ  
ЗАХИРАЛ

Х.ДУГЭР

2015 оны 05 сарын 15 өдөр

### Ажил гүйцэтгэх гэрээ

2015 оны 05 дугаар сарын 15

Дугаар. 06

Улаанбаатар хот

### Гэрээ байгуулсан:

Нэг талаас “Ном Хур” ХХК-ийг төлөөлж /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ захиалгын менежер Г.Тунгалаг, нөгөө талаас Нийслэлийн Биеийн тамир, спортын газар -ыг төлөөлж ахлах мэргэжилтэн А.Болдмаа /цаашид “Захиалагч” гэх/ нар дор дурьдсан нөхцлийг харилцан тохиролцож “Улаанбаатар – Марафон 2015” олон улсын гүйлтийн тэмцээний хэвлэлтийн ажлуудыг хэвлэн гүйцэтгэхээр энэхүү гэрээг байгуулав.

### Нэг.

Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж тус бүр нэг хувь авах ба адил хүчинтэй болно.

### Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Ажил гүйцэтгэх хугацаа 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 2015 оны 06 дугаар сарын 06-ны өдөр хүртэл байна.

### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1. Ажил гүйцэтгэхэд шаардагдах стандартын шаардлага хангасан эх материал зураг, текст болон загвар бусад зүйлийг гүйцэтгэгчид шилжүүлэн өгнө.
- 3.2. Захиалга бэлэн болж хүлээж авахдаа захиалгаа шалгаж авах эрхтэй.
- 3.3. Ажил гүйцэтгэлийн төлбөрийг гүйцэтгэгч талд гэрээнд заасан нөхцлийн дагуу төлнө.

### Дөрөв. Ажил гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч тал нь захиалагчийн захиалгат ажилтай холбоотой бизнесийн болон бусад нууцыг чандлан хадгална.
- 4.2. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 4.3. Ажил гүйцэтгэхээр захиалагчаас авсан материалуудыг ажил дууссаны дараа захиалагчид буцаан өгнө.
- 4.4. Захиалсан ажлыг захиалагчийн зөвшөөрөлгүй хэвлэн олшруулахыг хориглоно. Хэрэв хэвлэн олшруулсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

### Тав. Ажил гүйцэтгэлийн үе шат, хөлс.

- 5.1 Захиалгын төрөл

1. Уут 600 ширхэг нэг бүрийн үнийг нь 2200 төгрөгөөр
  2. Гүйгчдийн энгэрийн дугаар 19800 ширхэг нэг бүрийн үнийг нь 300 төгрөгөөр тооцож, нийт 7.260.000/ долоон сая хоёр зуун жаран мянган төгрөг/-ийг гүйцэтгэгчид төлнө.
  3. Хулдаасан хэвлэл тогтоолгүй: Метр квадрат- 80<sup>М</sup> Нэгж үнэ 3000 төгрөгөөр
  4. Хулдаасан хэвлэл тогтоолттой: Метр квадрат- 180<sup>М</sup> Нэгж үнэ 4500 төгрөгөөр тооцон хэвлэж, хулдаасан хэвлэлийн үнийг гүйцэтгэлийн дүнг тооцож тусд нь шилжүүлнэ.
- Захиалагч ажлын нийт хөлсний 50%-тай тэнцэх зардлыг гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногт, үлдсэн 50%-тай тэнцэх зардлыг ажил дууссанаас хойш ажлын 3 хоногт багтаан тус тус нэхэмжлэхээр шилжүүлнэ .

### **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1. Захиалагч хөлсийг төлөхгүй хугацаа хэтрүүлсэн бол хоног тутамд нийт хөлсний 0.5 хувьтай тэнцэх алдангийг төлнө.
- 6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй болон зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нөгөө талдаа нөхөн төлнө.

### **Долоо. Маргаан шийдвэрлэх журам**

- 7.1 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлнэ.

### **Найм. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах журам**

- 8.1. Гэрээний хугацаа нөхцөлд өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 8.2. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

### **Ес. Талуудын хууль ёсны хаяг**

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Соёлын төв өргөө, Монголын Театрын музей,  
3-н давхарт, Нийслэлийн Биеийн тамир,  
спортын газар Утас: : +976-11-312785,  
+976-11-328977, 9917-8373

Ажил гүйцэтгэгчийн хаяг:

Сүхбаатар дүүрэг 8-р хороо Билэг  
дээд сургуулийн  
Утас: 11-315464, 11-314644,  
99010854

### **Гэрээ байгуулсан:**

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ  
НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР,  
СПОРТЫН ГАЗРЫН АХЛАХ  
А.БОЛДМАА



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ  
"НОМ ХУР" ХХК-НИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ



Б.ГАНДОЛГОР